Ус гэрэлт ирээдүйн ТӨЛӨӨ

- Ус
- Байгаль
- Хүн

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2013

www.wsrc.mn

Гарчиг

1. Хууль,эрх зүйн орчин
2. Судалгаа,дүн шинжилгээ
3. Хяналт,шалгалт
4. Сургалт хөгжил
5. Өргөдөл,гомдол шийдвэрлэх
6. Хэвлэл,мэдээлэл,сурталчилгаа
7. Гадаад болон дотоод хамтын ажиллагаа

Эрхэм зорилго

Монгол улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэн,дэлхийн жишигт нийцсэн чанар стандарт бүхий найдвартай,тэгш, хүртээмжтэй үйлчилгээг хот, суурины хэрэглэгчидэд хүргэх, баталгаажуулах оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.





Мэндчилгээ

Ч.Эрдэнэчимэг

Эрхэм хүндэт танд

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл нь 2013 онд хийсэн жилийн ажлаа дүгнэх, алдаа оноогоо хэлэлцэх, үйл ажиллагаагаа илүү сайжруулахаар чармайн ажиллаж байна.

Байгууллагын үндсэн зорилго нь хүн ам, аж ахуйн нэгж байгууллагыг цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг зах зээлийн нөхцөлд үр ашигтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний үнэ, тарифыг бодит зардалтай нь уялдуулан, хэрэглэгч, хангагчийн эрх ашгийг тэнцвэртэйгээр хамгаалах зарчимд үндэслэн тогтоох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах явдал юм.

Тус салбарт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 120-д байгууллага, аж ахуйн нэгж 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Зохицуулах зөвлөлөөс тэдгээрийн усны үйлчилгээний үнэ тарифын нэгдсэн бодлого боловсруулах, үнэ тарифын тогтолцоог шинэчлэх, тусгай зөвшөөрөл олгож, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ үүгээрээ дамжуулан олон улсын усны үйлчилгээний байгууллагуудад мөрдөгдөж байгаа гүйцэтгэлийн үзүүлэлт, дэвшилтэт арга, хэлбэр, стандартыг нэвтрүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, улмаар хөгжингүй орны түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Усны үйлчилгээний үнэ тарифыг нэг түвшинд удаан барьснаас салбарын байгууллагууд хүнд байдалд ороод байгаа бөгөөд үүнийг даван туулахад усны үйлчилгээний үнэ тарифыг яаралтай шийдвэрлэх, салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, усны үнэ тарифыг улс төрөөс ангид байлгах нь чухал болоод байна.

Бид салбараа хөгжүүлэх, цаашдын ирээдүйд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг бүх нийтэд тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэхийн төлөө олон нийтийн оролцоог хангаж, та бүхний санал бодол, дэмжлэгийг тань үргэлж баяртайгаар хүлээн авч ажиллах болно.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

1. Хууль, эрх эүйн чиглэлээр

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8 дах заалтын дагуу Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ААНБ /хангагч/ болон үйлчилгээг хүртэж буй иргэд,байгууллагууд /хэрэглэгч/-ын хооронд үүссэн өмч хөрөнгө, зааг эзэмшил, төлбөр тооцоо, ашиглалтын маргааныг зохицуулах зорилгоор **"Аж ахуйн харилцааны дүрэм"**-ийг боловсруулж, 2013.03.26-ны өдрийн Зохицуулах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан болно.

Энэхүү дүрмийг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 1.6.4-т заасны дагуу Хууль зүйн яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж 2013 оны 11 дугаар сарын 04-ны өдөр нийтлэгдсэнээр нийтээр даган мөрдүүлж эхэллээ.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтын дагуу төвлөрсөн ус хангамж,ариутгах татуургын сүлжээнд хэрэглэгчийг холбох **"Техникийн нөхцөл олгох журам"**-ыг холбогдох баримт бичиг, норм дүрмийг үндэслэн боловсруулж, УСУГ болон ОСНААУГ-ын харьяа 11 конторoос албан ёсоор санал авч тусган Зохицуулах зөвлөлийн 10 дугаар сарын 25-ны хурлаар батлуулав. Улмаар Хууль зүйн яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэн бөгөөд 2014 оны 1 дүгээр улирлаас энэхүү журмыг албан ёсоор мөрдүүлэх төлөвлөгөөтэй байна.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасны дагуу **Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг** тусгай зөвшөөрлийн ангиллуудаар 4 бүлэгт хуваан боловсруулж, Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2013 оны 7

дугаар сарын 09-ны өдрийн зөвлөлийн ээлжит хурлаар батлав. Улмаар Хууль зүйн яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэн болно.
Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах үүднээс Зохицуулах зөвлөлийн хурлаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулах гэрээний загварыг баталж, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад гүйцэтгэлийн гэрээ байгуулан хэрэгжилтийг дүгнэн, биелэлтийг хангуулан ажиллаж байна. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлэн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох асуудлыг 3 хүртэл сараар хойшлуулах арга хэмжээ авдаг болно. Тус Зохицуулах зөвлөлөөс одоогоор нийт 117 байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээлтэй холбогдуулан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хууль,эрх зүйн хүрээнд судлан тухайн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн саналыг боловсруулж, УИХ-ын гишүүд болон холбогдох яам, агентлаг, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах аж ахуйн нэгж, байгууллагуудад материал бүрдүүлэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор гарын авлага зөвлөмжийг төрөлжүүлэн гаргав.

Үүнд:

1. Хөдөө,орон нутгийн ус сувгийн ашиглалт,үйлчилгээ
2. Орон сууцны ашиглалт, үйлчилгээ
3. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт,үйлчилгээ
4. Цэвэр усны үйлдвэрийн ашиглалт,үйлчилгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дах заалтад тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа,хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах байгууллагуудын бүртгэлийн маягтыг сайжруулж, мэдээллийг шинэчлэн тогтоов.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дах заалтын дагуу Зохицуулах зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохицуулалт үйлчилгээний хөлс тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж сайжруулсан болно.

СӨХ-ны Дээд зөвлөлөөс боловсруулж буй "СӨХ-ны эрх зүйн байдал, орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай" хуулийн төслийн шинэчилсэн найруулгад саналаа боловсруулж хүргүүлэв.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирсэн санал гомдлын дагуу судалгаа явуулж Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг багасган тогтоох саналыг Зохицуулах зөвлөлөөс БХБЯ-нд 2012 оны 12 дугаар сарын 24-ны өдөр хүргүүлсэн бөгөөд уг санал дэмжигдсэнээр Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 136 дугаар тогтоолоор **Улсын тэмдэгтийн хураамжийг 400.000 төгрөг** болгон бууруулсан нь Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудад тулгарч байсан зарим дарамтыг бууруулах ач холбогдолтой боллоо.

Зохицуулах зөвлөл 1998 оноос 2009 онуудад хэрэгжсэн болон хэрэгжиж буй төслүүд болох Азийн хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци (Дэлхийн банк),БНФУ-ын Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжсэн төслийн зээлийн гэрээний дагуу олгогдсон нийт 150.9 тэрбум төгрөгийн зээл, зээлийн хүүг тэглэх буюу улсын хөрөнгө оруулалт болгох талаарх санхүү, хууль зүйн хүрээн дэх судалгааны ажлыг БХБЯ-тай хамтран боловсруулж, холбогдох яам, тамгын газруудад санал оруулахаар ажиллаж байна.
Мөн Зохицуулах зөвлөлийн дотоод эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр шаардлагатай дүрэм, журам төслийг боловсруулан Зохицуулах зөвлөлийн даргын тушаалаар ажилчдын эрх ашигт нийцсэн "Ёс зүйн дүрэм" "Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" "Зохицуулах зөвлөлийн шагнал урамшуллын журам" "Зохицуулах зөвлөлөөс Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох шагналын журам"-ыг тус тус батлан мөрдүүлэн ажиллаж байна.

Хууль

2. Судалгаа, дүн шинжилгээ

Тус Зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албанаас Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9.1 дэх заалтад заасан чиг үүрэг, 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дараах судалгааг хийв.

Үүнд:

1.Ус хангамжи йн шугам сүлжээний элэгдлийн зардлын хувь хэмжээг тогтоох

2.Орон нутгийн түвшинд үнийг шийдвэрлэх

3.Ашиглалт, үйлчилгээний байгууллагын дундаж зардлын жишиг боловсруулах

4.ТЗЭ байгууллагуудын зардал нөхөж ажиллах түвшинг тогтоох

5.Алдагдалтай ажиллаж байгаа УСУГ болон нийтийн аж ахуйн байгууллагуудын алдагдлын хувь хэмжээг тогтоох

6.Усны үнэ тарифын хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ

7.Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын барилгын дотор сантехникийн засвар үйлчилгээний ажлын үнэ тарифыг шинэчлэн тогтоох

Улмаар үнэ, тариф шинэчлэх хүрээнд 2 талт тариф нэвтрүүлэх суурь судалгаанд үндэслэн **“Суурь үнэ тооцох аргачлал”** журам боловсруулан батлуулсан болно. 2 шатлалт тарифт шилжих болсонтой холбогдуулан усны үйлчилгээний төлбөр тооцох аргачлалыг иж бүрнээр нь шинэчлэн, цэвэр усны тариф тооцох, бохир усны төлбөр тооцох аргачлалуудын төслийг эхний хувилбараар боловсруулаад байна.

Ус сувгийн удирдах газар, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын харъяа ОНӨААТҮГ-ууд, аймаг орон нутгийн НАА-н байгууллага тус бүрээр **үнэ тарифын асуудлыг хянан боловсруулж, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ хийн** Зөвлөлөөр хэлэлцүүлж, “Өрсөлдөөний тухай” хуулийн дагуу ШӨХТГ-т саналыг хавсралтын хамтаар 9 удаа хүргүүлэв. Улмаар ШӨХТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу 2013 оны

3 дугаар улирлын дүнгээр үнийн саналыг шинэчлэн боловсруулж, 2013 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/545 тоотоор 10 дах удаагаа хүргүүлээд шийдвэр гаргахыг хүлээж байна.

Үнэ тарифын асуудлаар зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлгүүд:

- Ерөнхий сайд Н.Алтанхуягт 2 удаа
- Шадар сайд Д.Тэрбишдагвад 1 удаа
- БХБЯ-ны сайд Ц.Баярсайханд 2 удаа
- Усны үндэсний хороонд 2 удаа
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Төв, Увс, Баянхонгор аймгуудын ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нартай тус бүр 1 удаа
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар танилцуулга /удаа дараа/ Албан бичиг: Ерөнхийлөгчид,Их хурлын зарим гишүүдэд

Зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албанаас орон нутгийн түвшинд үнийг шийдвэрлэх асуудлыг судалж байгаа бөгөөд эхний ээлжинд сумын төвийн ус хангамжийн үйлчилгээний үнийн асуудлыг хэрхэн тухайн орон нутагт шийдвэрлүүлэх талаар судалгаа хийж, саналыг ШӨХТГ-т хүргүүлэхээр бэлдэж байна.

Мөн НАА-н байгууллагуудын зардлын шинжилгээ, хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалуудын төсөл бэлэн болгов.

Ус хангамж,ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт

хүргэх зорилгоор **“Гүйцэтгэлийн үзүүлэлт”**-ийг боловсронгуй болгох талаар УСУГ-ын гүйцэтгэлийн үнэлгээний мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна. Бидэнд ирүүлсэн тайлан мэдээнд үндэслэн ОСНААН 21, орон нутгийн 32 байгууллагын эдийн засаг,санхүүгийн холбогдолтой гүйцэтгэлийн үзүүлэлтийг боловсруулан урьдчилсан дүнг 6 үзүүлэлтээр гаргасан болно.

Мөн хот суурины ус хангамж,ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулах, чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор зохих тооцоо судалгааг хийж түүнд үндэслэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өрхийн тоо болон борлуулах усны хэмжээг тодорхойлон, саналыг Нийслэлийн ЗАА-д танилцуулаад байна. Уг тооцооны үр дүнд ОСНААН байгууллага доод тал нь 790-820 айл өрхөд цэвэр, бохир усны үйлчилгээ үзүүлснээр зардлаа нөхөн ажиллаж чадна гэсэн дүгнэлтэнд хүрсэн болно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үргүй зардлыг бууруулж алдагдлыг багасгах үүднээс айл өрх,ААНБ-ын тооноос хамаарсан шаардлагатай боловсон хүчний тоог тогтоохоор судалгаа хийв. Мөн Ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээ эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад **зардлын шинжилгээ хийх аргачлалын** төслийг боловсруулж байна.

Зохицуулах зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг **“Орон сууц нийтийн аж ахуйн байгууллагуудын барилгын дотор сантехникийн засвар, үйлчилгээний ажлын хөлсийг шинэчлэн тогтоох”** ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас төлбөрийн хуудас шинэчлэх судалгааг авч, нэгтгэв. Үүний үндсэн дээр орон сууцны төлбөрийн баримтын бичиглэлийг боловсронгуй болгож, цэвэр бохир усны төлбөрийг хэрэглэгчдэд тодорхой, ойлгомжтой хэрэглээгээ хянах нөхцөл бий болох юм.

3. Хяналт, шалгалт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагуудын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартад хяналт тавин ажиллаж байна. Улмаар ШӨХТГ-тай хамтран нийслэлийн хэмжээнд **Нийтийн аж ахуйн чиглэлээр тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, СӨХ, аж ахуйн нэгж, байгууллагуудад** шалгалт хийв. Үүний үр дүнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн заалтуудын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байгаа болно.

3.1. Орон сууц, ашиглалтын хүрээнд

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах заалтыг зөрчин тусгай зөвшөөрөлгүйгээр ус хангамж,ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ эрхлэн явуулж буй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, мөн СӨХ-ны статустай боловч орон сууцны ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа нийт 209 ААНБ-ын хаяг, байршил, эзэмшлийн судалгааг дүүрэг бүрээр гаргав. Эдгээрээс эхний ээлжинд Хан-Уул дүүрэгт явуулсан шалгалтаар 70 гаруй ААНБ тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 44 ААНБ, иргэн, СӨХ-г илрүүлж, тусгай зөвшөөрөл авах мэдэгдэл хүргүүлэв. Энэхүү мэдэгдлийн дагуу “Пюрхаус” ХХК, “Ган инженеринг” ХХК, “КСИМС” ХХК,“Эс жи ливинг” ХХК,“БЧГ” ХХК, “Батбаян дулаан” ХХК, “СТНАА” ХХК зэрэг компаниуд тусгай зөвшөөрөл шинээр авч, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж

байна. Үлдсэн 202 ААНБ, хувь хүн, СӨХ-д орон сууц, нийтийн аж ахуйн конторын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй явуулж байна.

Үүнд
- *СӨХ-30*
- *Аж ахуйн нэгж байгууллага-148*
- *Хувь хүн-24*

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2012 оны 30 дугаар тогтоолоор менежментийн хувьчлалд байсан орон сууцны конторуудыг нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилсөнтэй холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2013 оны 1-р сарын 15-ны өдрийн №1/46 тоот албан бичгээр ОСНААУГ-т харъяа 20 байгууллагууд болох ОНӨААТҮГ-д шинээр тусгай зөвшөөрөл авах мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд нийт 20 байгууллага тусгай зөвшөөрөл шинээр авч үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2. Цэвэрлэх байгууламжийн хүрээнд:

Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй том болон жижиг оврын цэвэрлэх байгууламжуудын тоног төхөөрөмж, хүчин чадал, цэвэрлэгээний арга, өмчийн хэлбэр, байгаль экологид нөлөөлж буй хөрсний бохирдлын хэм хэмжээ, ашиглагдаж буй эсэх зэргийг тусган цэвэрлэх байгууламжуудын нэгдсэн дэлгэрэнгүй судалгааг дүүрэг бүрээр гарган мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна. **Мэдээллийн санд** өнөөдрийн байдлаар УБ хотод 18, орон нутагт 107, нийт 125 цэвэрлэх байгууламж байгаагаас улсын хэмжээгээр хэвийн ажиллагаатай 51, хагас ажиллагаатай 27, ажиллагаагүй 47 байна.

Судалгаанаас харахад Нийслэл болон аймгийн зэрэглэлтэй хотуудын цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд сум, суурин газруудын

цэвэрлэх байгууламжогтажиллагаагүй болсноос эдгээр газруудын хүн амын хэрэглээнээс гарсан бохир ус ямарч цэвэрлэгээгүй, хөрсөнд шууд хаягдаж байгаа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байна. Ажиллагаагүй байгаа цэвэрлэх байгууламжууд нь ихэвчлэн 1980-1989 оны хооронд ашиглалтанд хүлээн авч байсан ба эдгээрт өнөөг хүртэл техник технологийн шинэчлэл хийгдээгүй байна. Монгол улсын хэмжээнд ашиглалтанд орсон нийт цэвэрлэх байгууламжуудын дөнгөж тал хувь нь хэвийн ажиллагаатай байгаа нь цаашид энэ чиглэлийн бодлого зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

3.3. Цэвэр ус олборлон, цэвэршүүлэх хүрээнд:

Улсын хэмжээнд ус олборлон савлан, зөөвөрлөн түгээж, хэрэглэгчдийг ундны усаар хангагч 60 гаруй ААНБ-ууд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дах заалтын дагуу нийслэлд дээрх үйл ажиллагаа явуулж буй нийт 32 усны үйлдвэрүүдийн хэрэглэгчдэд шууд түгээдэг ундны усны чанарын стандарт, эрүүл ахуйн шаардлага, эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хяналт тавих, зохицуулах зорилгоор мэдэгдэл хүргүүлснээс "Жем Хужирт" ХХК, "Блү Голд" ХХК, "Роял Ойл" ХХК, "Азийн хүлэг" ХХК, Тесо корпораци зэрэг компаниуд тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд цэвэр усны үйлдвэрүүдийн судалгаа хийгдэж, улмаар төвлөрсөн шугамаас болон гүний худгаас ус олборлон цэвэршүүлэх технологи, усны чанар, усны эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэх болон тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнд нь хяналт тавин ажиллах нөхцөл бүрдэж байна.

3.4. Бохир усыг тусгай эориулалтын машинаар соруулж, татан эайлуулах ажил, үйлчилгээний хүрээнд:

Монгол Улсын Хот,суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.14 дэх заалтад заагдсан айл өрх, албан байгууллагуудын бохир усыг тусгай

зориулалтын машинаар татан зайлуулах үйл ажиллагааг хууль зөрчин явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг судалгаагаар илрүүлэв. Эдгээр байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах, зориулалтын бохирын машинаар төвлөрсөн шугамын хаях цэгүүдэд хяналтын дор нийлүүлэхэд нь хянах зорилгоор тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг шаардаж, албан мэдэгдэл хүргүүлээд байна.

Нийслэл хотын хэмжээнд ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбогдоогүй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн бохир усыг хувь хүмүүс ямар ч хяналтгүй соруулан тээвэрлэж, ариутгах татуургын төвлөрсөн шугамд дур мэдэн нийлүүлснээр тухайн системийн хэвийн ажиллагааг доголдуулах, эвдрэл гэмтэл учруулах, түүнчлэн зарим тохиолдолд цэвэр усны

шугамын худагт бохир ус хаяж, хүн амын ундны усыг найдвартай хангах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх явдал гарч байна. Иймд бохир ус соруулан тээвэрлэх үйл ажиллагааг хууль зөрчин эрхэлж байгаа иргэдийг судалгаагаар илрүүлсний үндсэн дээр нийт 100 орчим иргэдийн бүртгэлийг гаргасан болно.

Эдгээр иргэд, аж ахуйн нэгж, байгуулагууд нь хоногт 180 орчим тн бохир усыг төвлөрсөн ариутгах татуургын системд нийлүүлдэг байна. Түүнчлэн УСУГ-аас ариутгах татуургын системд бохир ус нийлүүлэх цэгүүдийг дүүрэг бүрт нээж, ажиллуулах эдгээр цэгүүдийг камержуулж хянах, ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, тусгай зөвшөөрөлгүй бохир ус зөөвөрлөж буй иргэдийг тус зөвлөлд мэдээлэх зэрэг асуудлаар хандаж, тодорхой ажлуудыг гүйцэтгүүллээ.
Улмаар Зохицуулах зөвлөлөөс нийт 100 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авах талаар заавар, зөвөлгөө өгөв.

Үүний үр дүнд 20 гаруй иргэд нэгдэн

“Урашка” ХХК, “Эко жоб” ХХК, “ Томмасс” ХХК, “Бат урсгал” “Азын завод” ХХК зэрэг хуулийн этгээд болж, тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байгаа бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний үнэ тариф, төлбөрийн үндэслэлийг тогтоох, хуулийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавин ажиллаж байна.

3.5. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах

Зохицуулах зөвлөлөөс Нийслэлийн 6 дүүрэг болон Өмнөговь, Ховд, Сэлэнгэ, Хөвсгөл, Дорноговь, Говьсүмбэр, Орхон, Төв, Дархан-Уул аймгийн нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, зохих мэргэжлийн дүгнэлт, шийдвэрүүдийг гарган ажиллав.

Мөн тусгай зөвшөөрөл шинээр авах буюу сунгуулах хүсэлт гаргасан Орон нутгийн өмчит орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллага 4, Хувийн орон сууц ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг байгууллага 20, Цэвэр усны үйлдвэр 3, Бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ үзүүлдэг 1, Монгол Орос хувь нийлүүлсэн нийгэмлэг 2, Ус суваг ашиглалтын 3, нийт 68 байгууллагуудын

үйл ажиллагаатай газар дээр нь очиж тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангаж буй эсэхийг шалган ажиллав. Үүний үр дүнд шугам сүлжээний шинэчлэл, шинэ техник технологи нэвтрүүлсэн байдал, ИТА-ын хүний нөөц, чадавхыг сайжруулах, зардлыг бууруулж үр ашигтай ажиллах талаар мэргэжлийн дүгнэлт гарган цаашид гүйцэтгэх ажлын чиг үүрэг өгч үр дүнг хянан ажиллаж байна.

3.6. Бусад хүрээнд:

Зохицуулах зөвлөлөөс Нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах явцад Улаанбаатар төмөр

замын барилга орон сууцны 1-р анги, Улаанбаатар төмөр замын барилга орон сууцны 3-р анги, Эрчим хүч ус хангамжийн 1-р анги, Эрчим хүч ус хангамжийн 2-р анги зэрэг байгууллагууд Төмөр замын харьяанд үйл ажиллагаа эрхэлдэг байсан нь мэргэжлийн байгууллагын хувьд бэхжээгүй, биеэ дааж ажиллах чадвар сул,чадавхгүй байдалд хүрснийг тогтоов.

Дээрх байгууллагууд Хот,суурины ус хангамж,ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан ангиллуудаар үйл ажиллагаа эрхэлдэг тул тусгай зөвшөөрөлд хамруулж, Нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын бүлд нэмлээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж,байгууллагуудын үйл ажиллагааны тайлан мэдээг 2012 оны жилийн эцсийн болон 2013 оны 3 дугаар улирлын байдлаар авч нийт 89 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гарган Зөвлөлийн хуралдаанд танилцуулан,цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг мэргэжил арга зүйн зөвөлгөөгөөр хангах, удирдамж чиглэл хүргүүлээд байна. Дээрх 89 байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээ хангалтгүй байгаагаас, тэдгээрийн хариуцаж буй барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, хүний нөөц, техник технологи болон эдийн засгийн үзүүлэлтийн талаар орон нутаг болон нийслэлээр гаргах мэдээллийн сангийн бүрдүүлэлт 80%- тай байна.

4. Сургалт хөгжлийн чиглэлээр

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг чадавхжуулах чиглэлээр

Зохицуулах зөвлөлөөс үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах зорилгоор Нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудад сургалт семинарыг зохион байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд Орон сууцны конторын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн компаниудад зориулж **“Хувийн хэвшлийн орон сууцны компаниудын уулзалт хэлэлцүүлэг”**-ийг 2013 оны 03 сарын 25-ны өдөр амжилттай зохион явууллаа. Уг хэлэлцүүлэгт 23 компанийн удирдлага оролцож, санал хүсэлтээ ирүүлэв. Хэлэлцүүлгийн үеэр Тусгай зөвшөөрлийн албанаас “Зохицуулах зөвлөлөөс олгож буй тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдвээр илтгэл тавьсан болно. Мөн хувийн хэвшлийн ОСНАА-н конторуудын өмнө тулгарч буй асуудлыг нээлттэй хэлэлцэн цаашид авах арга хэмжээний талаар харилцан санал солилцсон бөгөөд энэ уулзалтын дүнд СӨХ-ны статустай боловч орон сууцны конторын үйл ажиллагаа явуулж буй СӨХ-уудын нэрс, байршлын мэдээллийг саналын хуудсаар авч, илрүүлэн тусгай зөвшөөрөл авах тухай мэдэгдэл хүргүүлэв.

Хөдөө орон нутгийн ус хангамж,

ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын инженерүүдэд зориулсан сургалт семинарыг 2013 оны 1-р сарын 14-д ШУТИС-иас зохион байгуулсан ба нийт 36 байгууллагын 28 төлөөлөгч оролцов. Семинарын үеэр Зохицуулах зөвлөлөөс зөвлөлийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн журам, тавигдах шаардлагын талаар танилцуулга хийлээ.

Нийслэл хотын хэмжээнд цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, савлах үйл ажиллагааг эрхэлж байгаа нийт ААНБ-уудад усны чанар, шинэ техник технологи болон эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар

"Цэвэр усны чанар ба эрүүл ахуй" сэдвээр 2013 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн байранд сургалт зохион байгуулсан ба нийт 36 байгууллагын 20 гаруй төлөөлөгч оролцсон юм. Оролцогчдод цэвэр усны үйлдвэрүүдэд нэвтэрч буй шинэ болон дэвшилтэт техник технологи, усны чанар, аюулгүй байдал, савалсан усны стандарт, түүний үзүүлэлтүүд, уснаас хамааарч гарах өвчлөлүүд, усыг халдваргүйжүүлэх арга зэрэг сэдвүүдээр мэдээлэл, зөвлөмж өглөө.

НҮБ-ын "Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах" -MON/08/302 төслөөс санал болгосны дагуу 2013 оны 10 дугаар сарын 21-нээс 25-ны өдрийн хооронд Өмнөговь аймгийн Булган сум, Ховд аймгийн Зэрэг суманд "Баригдсан ус хангамжийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээ түүний зориулалт", **"Барьж ашиглалтанд оруулсан ус хангамж, ариутгах татуургын иж бүрэн системийн ашиглалт, үйлчилгээ"** сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, үүнд 20 орчим мэргэжлийн ажиллагсад болон тухайн сумын удирдлагууд, иргэдийг оролцуулав.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах "GO204-MON" төслийн хүрээнд хийгдсэн Ус хангамж, ариутгах татуургын системийн ашиглалтыг хариуцах мэргэжилтнүүдэд **"Ус хангамж, ариутгах татуургын системийн онолын мэдлэг олгох болон туршлага солилцох"** нь сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Сургалтыг Замын-Үүд хотын захирагчийн ажлын албатай хамтран 2013 оны 11 дүгээр сарын 25-аас 29-ний өдрийн хооронд зохион байгуулсан ба нийт 18 хүн оролцов.

Үүний үр дүнд салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах улмаар туршлага солилцож, өнөөгийн ус хангамж, ариутгах татуургын шинэ техник технологитой

танилцсан бөгөөд цаашид дээрх сургалтуудыг үе шаттайгаар явуулах саналыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлээд байна.

4.2. Дотоод сургалт, хөгжлийн чиглэлээр

Зохицуулах зөвлөлөөс хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд ШУТИС-ийн Хүрээлэн байгаа орчны танхимтай хамтран "Ус хангамж, ариутгах татуургын системийн хөгжлийн тухай", Барилгын хөгжлийн төвд зохиогдсон "Австралийн бага оврын цэвэрлэх байгууламжийн тухай, түүний үйл ажиллагааг танилцуулах", Архивын Ерөнхий Газраас зохион байгуулдаг Архив,бичиг хэргийн мэргэжил олгох, Монголын хөгжлийн гарц ТББ-аас зохион байгуулдаг "Жуумла агуулга удирдах систем", Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулдаг мэргэшсэн инженерийн зэрэг авах, эрх сунгуулах, МУИС-ийн ЭЗС-ийн Бизнес хөгжлийн төвд ЗГ-ын хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны А-3 зэрэглэлтэй 3 хоногийн сургалт, АТГ-аас зохион байгуулсан ХАС, ХОМэдүүлэг гаргах албан тушаалтнуудаас мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, эрх бүхий албан тушаалтны сургалтад давхардсан тоогоор нийт 20 ажилтанг сурган мэргэшүүлэв.

Мөн Барилгын Хөгжлийн Төвтэй хамтран "Саарал усны стандарт"-ын талаарх хэлэлцүүлэгт "Саарал усыг ашиглах, техникийн ерөнхий шаардлага" стандартад санал боловсруулж хүргүүлсэн бөгөөд судалгааны баг бүрдүүлж оролцов. Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх усны бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан "Усны хэлэлцүүлэг"-т "Монгол Улсын ус хангамж, аритгах татуургын өнөөгийн байдал" сэдэвт илтгэл тавьж салбарын тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга хийв.

5. Өргөдөл, гомдол шийдвэрлэх чиглэлээр

2013 оны байдлаар Зохицуулах зөвлөл нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 112 өргөдөл гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.

Өргөдөл,гомдол шийдвэрлэлт		2013
Нутаг дэвсгэрийн харъяалал		
Монгол улс	Улаанбаатар хот	89
	Хөдөө орон нутаг	23
Ирсэн өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл		
Үйл ажиллагаатай холбоотой санал гомдол		14
Дотоод ажилтай холбоотой		25
Төлбөрийн хуудас шалгуулах тухай		7
Үнэ тариф нэмэгдүүлэх тухай		66



6. Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр

УСУГ, ОСНААУГ-тай хамтран 2013 оны 03 дугаар сарын 22-нд “Усгүй ирээдүйгээр 2 цаг аялъя” сэдэвт хэвлэлийн бага хурал зохион байгуулж салбарт тулгамдаад буй тулгамдсан асуудлыг телевиз, вебсайт зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэв.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагаагаа сурталчлан таниулах, Ус хангамж ариутгах татуургын үйлчилгээний чанар, хүртээмж, үүсч буй бэрхшээл, усны үнэ цэнийг сурталчлах, усны зохистой хэрэглээг олон нийтэд хэвшүүлэх зорилгоор “Хэвлэлийн эрх чөлөө” ТББ-тай хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, гэрээнд тусгагдсаны дагуу мэдээ, мэдээлэл, захиалгат нэвтрүүлэг болон сонин сэтгүүл, вэб хуудсуудад нийтлэл бэлтгэн хэвлүүлж байна.

Мөн уг ажлын хүрээнд MYOHT, NTV, Eagle, TV-9, TM, ZA , MNC, 25-р суваг, C1, ECO, SBN мэдээний алба, UBS мэдээний алба, Өдрийн сонин, Өнөөдөр сонин, “Бизнес таймс” сонин, “Бизнес ба хөгжил” сэтгүүл, “Орчин 21” сэтгүүл болон бусад цахим сайт, мэдээллийн хэрэгслүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна.

“Усыг 24 цаг бэлэн байлгахад бэрх боллоо”, ”Ус хангамжийн үйлчилгээг суурь үнэтэй болгоё”, ”Хатан туул бохироор урсаж, хот бохиртоо умбах гэж байна” сэдэвт богино хэмжээний цуврал кино хийлгэж телевизийн сувгуудаар давтамжтайгаар нэвтрүүллээ.

Түүнчлэн ММ агентлагийн “Асуудал хөндсөн сэдэв” 7 хоногийн цуврал, мэдээ мэдээллийн хөтөлбөрүүдээр салбарын инженер техникийн мэргэжилтэн, эрдэмтэн судлаачдыг оролцуулсан 30 гаруй хэлэлцүүлэг нэвтрүүлгүүд бэлтгүүлж төлөвлөгөөний дагуу олон нийтэд хүргэж байна.

Мэдээ мэдээллийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн Нийтийн аж ахуйн байгууллагуудын өнөөгийн байдал тулгамдсан асуудлуудыг газар дээрээс нь сурвалжилж сурталчлав.
Цаашид 11 веб сайт, 2 сонин, 3 сэтгүүл, 15 телевизтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.

7. Гадаад болон дотоод хамтын ажиллагааны чиглэлээр

7.1. Гадаад хамтын ажиллагаа

Байгууллагын зүгээс төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай харилцах, үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, гадаадын болон олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгууллаа.

Эй Си Эф Францийн олон улсын байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулсны дагуу Монгол Улсын шийдвэр гаргах эрх бүхий холбогдох байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор **“Хотын эмзэг бүлгийнхэнд зориулсан усны үнэ тариф”** сэдэвт семинарыг ACF Монгол олон улсын байгууллага, Францын Усны Агентлагтай хамтран зохион байгуулж, “Нийслэл болон орон нутагт хэрэгжүүлэх эмзэг бүлгийнхэнд зориулсан үнэ тариф” сэдэвт илтгэл тавив. Мөн Эй Сй Эф Монгол олон улсын байгууллага болон Нийслэлийн боловсролын газартай хамтран Ерөнхий боловсролын сурагчдын дунд “Усаа гамтай хэрэглэе” сэдэвт фото зураг, видео бичлэгийн уралдаан зарлан, шалгарсан бүтээлүүдээр олон нийтэд зориулан үзэсгэлэн гаргасан нь дунд сургуулийн сурагчдад усны үнэ цэнийг ойлгуулсан, танин мэдэхүйн ач холбогдолтой арга хэмжээ болов. Энэхүү арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар 2 тал тохиролцлоо.

Япон улсын Токио хотын “Metropolitan” байгууллагатай холбоо тогтоон Японы ус сувгийн байгууллагын үйл ажиллагааны менежмент, усны төлбөрийн өнөөгийн тогтолцоо, өртөг тооцох аргачлалын талаарх сургалтад үнэ тарифын албаны дарга, мэргэжилтнүүд хамрагдаж, гарын авлага, сургалтын материалаар хангагдав. Мөн Английн “Ofwat” усны үйлчилгээг зохицуулах байгууллагын үйл ажиллагаатай танилцан, үнэ тарифын асуудлаар хэрхэн ажилладаг туршлага судлан ажиллаж байна.

Гишүүнээр элссэн олон улсын байгууллагууд болох International Water Association, Global Water Partnership, Water Supply and Sanitation Collaborative Council байгууллагуудын гишүүнчлэлийг баталгаажуулан тухайн байгууллагуудаас цаг тухайд нь мэдээлэл авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Дээрх байгууллагуудад гишүүнээр элссэний үр дүнд олон улсын шинж чанартай сургалт семинаруудад ажилтан албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр суралцуулах боломж нөхцлөөр хангагдаж байна. Улмаар зохион байгуулагдаж буй сургалт семинарт ажилтан албан хаагчид болон Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын боловсон хүчний анкетийг илгээж, холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг хангасан ажилтан албан хаагчдыг дараах сургалт семинарт хамрууллаа.

2013 оны 01 дүгээр сард АЭНУ-ын Абу Даби хотноо зохион байгуулагдсан ОУ-ын усны байгууллагуудын үзэсгэлэн семинар

2013 оны 05 дугаар сард Сингапурын Үндэсний Их сургууль болон Темасек сангаас жил бүр хамтран зохион байгуулдаг “Ус,салбарын удирдлага” туршлага судлах сургалт 14 хоног,/ОСНААУГ-ын төлөөлөгч/

2013 оны 10-р сард БНСУ-ын Дейжон хотод зохион байгуулагдсан Азийн усны байгууллагуудын “HRM –A1D” хүний нөөцийн түншлэлийн сургалт /3 хоног/

2013 оны 11-р сард БНХАУ-ын Бээжин хотод Хятадын Засгийн газрын тэтгэлэгээр зохион байгуулагдсан “Ус хангамж ба усны эрүүл ахуй,усны хэрэглээ” сэдэвт хөгжиж буй орнуудыг дэмжих сургалт 14хоног,/УСУГ-ын төлөөлөгч/

7.2. Дотоод хамтын ажиллагаа

Зохицуулах зөвлөлөөс санаачлан нийтийн аж ахуйн салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн зах зээлд шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ тарифын өөрчлөлтийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад талуудын хамтын ажиллагаа, түүний үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай санал солилцсоны үндсэн дээр **"Хамтран ажиллах санамж бичиг"**-ийг үйлдэв. Уг санамж бичгийн хүрээнд ШӨХТГ-тай хамтран нийслэлийн хэмжээнд нийтийн аж ахуйн чиглэлээр тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, СӨХ, аж ахуйн нэгж, байгууллагуудад шалгалт хийж, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн заалтуудын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр шинээр батлагдан гарч буй хууль тогтоомжийг энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, Улсын Их хурлаар хуулийн төслийг хэлэлцэх явцад харилцан мэдээлэл солилцох, ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч УСУГ, ОСНААУГ-ын харъяа орон нутгийн өмчит компаниуд болон хувийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, цэвэр, бохир усны үнийг шинэчлэн тогтоох, усны алдагдлыг бууруулах, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг чиглэлээр Нийслэлийн Захирагчийн Ажлын Албатай "Хамтран ажиллах санамж бичиг"—т гарын үсэг зурж хамтран ажиллаж байна.

Байгаль орчин ногоон хөгжлийн яамтай хамтран “Ус ашиглалт,хэрэглээг тоолууржуулах журам”,“Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” зэрэг төсөл, тогтоолын төслүүдийн судалгааны багт хамтран ажиллав.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний чанар,хүртээмж,өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Хэвлэлийн эрх чөлөө” ТББ-тай 2013 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс хамтран ажиллах тухай гэрээ байгуулан ажиллаж байна.

Зохицуулах зөвлөлийн 2013 оны Санхүүгийн үйл ажиллагааны тайлан /мян.төг/

Эдийн засгийн ангилал	Орлого, зардлын дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувиар
Ажил,үйлчилгээний орлогын дүн	594,665.50	456,648.20	77%
Зохицуулалт үйлчилгээний орлого	594,665.50	449,240.50	
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		7,407.70	
Зардлын дүн	594,665.50	432,132.50	73%
Цалин,хөлс,нийгмийн даатгалын шимтгэл	344,588.00	241,235.40	70%
Бичиг хэрэг,шуудан холбоо,тээвэр шатахуун,	16,133.60	14,435.50	89%
Байрны түрээс,урсгал засвар	54,672.00	52,249.60	96%
Сургалт судалгаа,албан томилолт хурал,зөвлөгөөн	39,802.50	12,350.00	31%
Хэвлэл мэдээлэл,сурталчилгаа	15,000.00	15,025.00	100%
Төлбөр хураамж,бусад зардал	19,818.00	8,714.30	44%
Эд хогшил худалдан авах,элэгдлийн зардал	16,880.00	12,722.70	75%
Дотоод хөрөнгө оруулалт	91,000.00	75,400.00	83%
Ажиллагсдын тоо	26	22	

Цаашдын зорилго

Зохицуулах зөвлөл үүсгэн байгуулагдсанаас хойш Усны үйлчилгээний үнэ тариф тогтоох, Тусгай зөвшөөрөл олгох, түүний биелэлтэд хяналт тавих чиглэлээр тодорхой ажлуудыг шат дараатай хийж ирсэн бөгөөд үүний үр дүнд байгууллагын үйл ажиллагаа тогтворжиж байна. Цаашид Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгууллагын бие даасан хараат бус байдлыг хангах, Зохицуулах зөвлөлийг бэхжүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг ханган ажиллах шаардлагатай байна.

Мөн Нийтийн аж ахуйн салбарын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулахад БХБЯ болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Ус хангамж,ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Нийслэл болон орон нутгийн Нийтийн аж ахуйн байгууллагуудад хяналт шалгалт явуулж, үйл ажиллагаанд нь мониторинг хийж мэргэжлийн дүгнэлт гаргах ажлыг үргэлжлүүлэн үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллах бөгөөд энэ нь хэрэглэгчдэд үзүүлэх ус хангамж, ариутгах татуургын байгууллагын үйлчилгээг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн санг байгуулан шинэчлэн баяжуулж, БХБЯ-ыг тогтмол мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй.

Мөн Нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын удирдах болон санхүү бүртгэлийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, салбарын мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулан улмаар нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.

Улмаар 2014 онд Усны үйлчилгээний тарифыг шинэчлэн батлуулж, суурь хураамж нэвтрүүлэх,эрх бүхий байгууллагатай хамтран усны үйлчилгээний үнэ тарифын нэгдсэн бодлого боловсруулж, үнэ тариф тогтоох, шинэчлэн өөрчлөх асуудлыг улс төрөөс хараат бусаар,индексжүүлэн шийддэг байхыг хуульд тусгуулан ажиллах зорилт тавин ажиллаж байна.

Усны үйлчилгээний үнэ тарифын бодлого боловсруулж, бүтцийг шинэчлэхийн тулд олон нийтэд бодит,үнэн зөв мэдээлэл хүргэх нь чухал юм. Иймээс Нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн санхүү,эдийн засгийн нөхцөл байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, цуврал нэвтрүүлэг бэлтгэх замаар усны үнэ цэнийг ойлгуулж, усны зүй зохистой хэрэглээг хэвшүүлэх талаар цаашид анхааран шат дараатай ажлыг зохион байгуулж ажиллах болно.